

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ХАМТАРСАН БАГ

ТОВХИМОЛ

7

ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ
ОРОЛЦОО



Хөдөлмөр,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Save the Children

Хүүхдийг Ивээх Сан нь дэлхийн 120 оронд хүүхдийн эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус, олон улсын байгууллага юм. Монгол Улсад 1994 оноос тогтвортой үйл ажиллагаа явуулж, Боловсрол, Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал хөтөлбөрүүдийн хүрээнд үйлажиллагаагаа явуулж байна.

©Хүүхдийг Ивээх Сан, 2016 он

Боловсруулсан: Б.Сүх–Очир
Хянан тохиолдуулсан: Х.Өлзийтунгалаг
Гарын авлагын зургийг Г.Ганбаяр

Хүүхдийг Ивээх Сан
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
I дүгээр хороо, Аризона төв, 4–р давхар

Шуудангийн хайрцаг:
Төв шуудан, ш/х–1023, Улаанбаатар хот 13, Монгол Улс

Утас: +976–11–329365,
+976–11–329371

Факс: (976–11) 329361

И–Мейл: secretary@savethechildren.mn

Facebook: Save the Children in Mongolia

Twitter: Save the children MN

Вэб: www.savethechildren.mn

ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ОРОЛЦОО

ХАЛАМЖИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН БА ХАМТАРСАН БАГ

Нийгэмд тулгарч буй асуудлууд аль нэг салбарын шийдвэрлэх асуудал бус, нийгмийн бодлого, хуулийн хэрэгжилтийг хангахад салбар дундын үр дүнтэй хамтын ажиллагааг шаардах болсон. Тухайлбал, хүүхэд хамгааллын асуудал боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн байгууллага ганцаарчлан үйлчилгээ үзүүлээд шийдвэрлэх боломжгүй, нарийн төвөгтэй, цогц асуудал болсон учраас хүүхэд хамгааллын хамтарсан багийг бий болгосон.

Хамтарсан багийн зорилго нь “Хороо, баг, сумын нутаг дэвсгэр дээр гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэл, бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллаж, хүчирхийллийн харилцаатай гэр бүл, эрсдэлтэй нөхцөл, эмзэг байдалд амьдарч байгаа хүүхдүүдэд төрөөс үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг хүргэх” явдал.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.1. “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг;

4.1.2. “нийгмийн ажилтан” гэж баг, хорооны, сургуулийн, нийгмийн халамжийн, эрүүл мэндийн, бусад салбарт ажиллаж байгаа нийгмийн ажил, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжилтэн, ажилтан, албан тушаалтныг;

4.1.3. “хүүхдийн эрхийн хууль зүйн хороо” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг;

4.1.4. “хууль зөрчсөн хүүхэд” гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэн, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл зөрчил үйлдэж шийтгэгдсэн, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлж, албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдийг;

4.1.5. “хамтарсан баг” гэж гэр бүлийн болон бусад орчинд үйлдэгдсэн хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх анхан шатны нэгжийг;

4.1.6. “хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” гэж эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагааг;

4.1.7. “хүүхдийн эрхийн ажилтан” гэж хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх бүхий ажилтан, албан тушаалтныг;

4.1.8. “хүүхдийн эсрэг хүчирхийлэл” гэж санаатай эсхүл санамсаргүйгээр хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжил, бие махбод, сэтгэл санаанд хор хохирол учруулах үл хайхрах байдал, бэлгийн зүй бус үйлдэл болон бие махбодийн шийтгэл, сэтгэл санааны дарамтыг.

Хүүхэд хамгааллын хуулиас...

Дээрх зорилгыг биелүүлэхийн тулд нийгмийн үйлчилгээний анхан шатны нэгж болох хороо, багийн түвшинд ажиллаж буй мэргэжилтнүүд хамтран ажиллаж, хүүхэд хамгааллын үйлчилгээг богино хугацаанд, чанартай хүргэх шаардлага тулгараад байна. Тэр дундаа хүүхэд хамгааллын талаар мэдлэгтэй халамжийн мэргэжилтнүүд (нийгмийн ажилтнууд) хамтарсан багт чухал оролцоотой юм.

Одоогийн байдлаар хамтарсан багт халамжийн мэргэжилтнүүдийн оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг хангалтгүй түвшинд байгаа бөгөөд оролцоо нь амьжиргааг дэмжих зөвлөлөөр батлагдсан үйлчлүүлэгчийн халамжийн материал бүрдүүлж авахад тусламж үзүүлэх төдийгөөр хязгаарлагдаж байна. Хамтарсан баг болон амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажилласнаар үйлчилгээний чанар сайжирч, олон нийтийн оролцоо нэмэгдэж, орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээ хөгжих боломж нэмэгдэх юм.

Одоогийн мөрдөгдөж байгаа дараах хуулиудаар хамтарсан багийн ажиллах эрх зүйн орчинг тусгасан байна. Үүнд:

- МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай үндэсний хөтөлбөр
- Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги /2010 - 2015/1.3.4, 1.4.4;
- Нийслэлийн Засаг даргын захирамж /2007 оноос хойш/
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль

15.4. Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаар нөхцөл байдлын үнэлгээ хийж, цаашид тухайн хүүхдэд шаардлагатай үйлчилгээний талаар дүгнэлт, зөвлөмж гаргах, яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх чиг үүрэг бүхий тухайн шатны хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон сургуулийн нийгмийн ажилтан, өрхийн эмч, цагдаагийн ажилтан, бусад мэргэжилтний бүрэлдэхүүнтэй хамтарсан багийг сум, хорооны Засаг даргын захирамжаар байгуулан ажиллуулна.

Хүүхэд хамгааллын хуулиас

Дээрх хууль тогтоомжуудаас гадна Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн үзэл баримтлал нь халамжийн нийгмийн ажилтнуудын эрх, үүрэг, бусад мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах боломжийг бүрдүүлж өгсөн давуу талтай байна. Тус хуулийн 27, 28 дугаар зүйлүүдэд халамжийн нийгмийн ажилтнуудын ажиллах эрх зүйн орчинг тусгасан байна.



28.8. Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

28.8.1. тухайн сум, хорооны нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх;

28.8.2. нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж, хэрэгжүүлэх;

28.8.3. тэтгэвэр, тэтгэмж авах, нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;

28.8.4. өрх, иргэдийг хүсэл, зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болгон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

28.8.5. өрх, иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь туслах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

28.8.6. орон нутгийн иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;

28.8.7. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих;

28.8.8. нийгмийн ажилтанд хандсан хувь хүний /хууль зөрчсөн үйлдлийг мэдээлэхээс бусад тохиолдолд/ нууцыг чандлан хадгалах;

28.8.9. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг хэрэгжүүлэх;

28.8.10. хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах.

28.8.11. иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний талаар бүрэн мэдээлэл өгөх;

28.8.12. өрх, иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд үр дүнтэй хамруулах зорилгоор эрүүл мэнд, боловсролыг дэмжих зэрэг нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх.

Нийгмийн халамжийн тухай хуулиас

Хүүхэд түүний гэр бүл хүчирхийлэл дарамтад өртөх шалтгаан нөхцөл нь олон хүчин зүйлээс хамаарсан байж болно. Нөгөө талаар тухайн гэр бүлтэй ажиллах, асуудлыг шийдвэрлэхэд нийгмийн халамжийн үйлчилгээтэй холбох шаардлага зүй ёсоор урган гардаг. Ийм л учраас халамжийн нийгмийн ажилтан тухайн кейсийг амжилттайгаар шийдвэрлэхэд дөхөм болно.

Халамжийн үйлчилгээ авч буй хүүхэд, гэр бүл ч хүчирхийлэлд өртөж болно. Энэ тохиолдолд халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багийн бусад гишүүдэд хандаж хүүхэд, гэр бүлд хамгааллын үйлчилгээг үзүүлнэ. Ингэж халамжийн нийгмийн ажилтан нь хороо/сум/багийн түвшинд ажиллаж буй нийгмийн ажилтантай хамтран ажилласнаар хүүхэд, түүний гэр бүлд цогц үйлчилгээг үзүүлдэг.

Халамжийн үйлчилгээ авч буй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, эмэгтэйчүүд, хөгшид хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байдаг гэдгийг санах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагатай гэж гарсан бол халамжийн үйлчилгээнд холбоно гэж заасан. Хүчирхийлэл дарамтад өртсөн, эсхүл өртөж болзошгүй, нийгмийн ажлын үйлчилгээ авч буй хүүхдийн эрсдлийн үнэлгээ болон гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хийхэд халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багт дэмжлэг үзүүлж ажилласнаар үнэлгээг үнэн зөв, бодитой хийх боломжийг бүрдүүлдэг.

14 дугаар зүйл. Дэмжих, холбон зуучлах үйлчилгээ

14.1. Нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд нийгмийн ажилтан холбон зуучилна.

Хүүхэд хамгааллын тухай хуулиас

Дээрх учир шалтгаануудын улмаас халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багийн бүтэц, үйл ажиллагааны талаар сайн мэдлэгтэй байх хэрэгцээ шаардлага гарахын зэрэгцээ хувь нэмрээ оновчтой байдлаар оруулж чадна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, хамгаалах гэсэн үе шатаар хэрэгждэг. Үйлчлүүлэгчийн тодорхой хэрэгцээ шаардлагаас шалтгаалан хамтарсан баг дээрх үйлчилгээнүүдийг хэрэгжүүлэх бөгөөд нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагаанаас илүү урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж чадвал хүүхэд хамгааллын олон асуудлыг хамтран шийдвэрлэх боломжтой юм.

Халамжийн нийгмийн ажилтны хувьд хамтарсан багт дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхэд оролцоно. Үүнд:

- Судалгаа хийх
- Сургалт, уулзалт зохион байгуулах
- Хууль сурталчилан таниулах
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулах
- Нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх

Халамжийн нийгмийн ажилтан нь төрийн анхан шатны нэгж дээр ажиллаж байгаа ажилтан болон мэргэжилтнүүдтэй харьцуулахад халамжийн үйлчилгээний талаар хамгийн сайн ойлголттой, төрийн бодлого болон боломжуудыг сайн мэддэг бөгөөд өөрийн ажлын чиг үүргийн хүрээнд хамтарсан багт хувь нэмрээ оруулах боломжтой.

Иргэд, олон нийт нийгмийн халамж, хүүхэд хамгааллын тухай хууль, дүрэм, журмын талаарх ойлголт мэдлэг муу байдаг бөгөөд халамжийн нийгмийн ажилтан эдгээр хууль, дүрмийн талаар иргэдэд ойлголт мэдлэг өгөх, орон нутгийн иргэдийн хөгжих, нийгмийн амьдралд оролцох сэдэл, идэвхи, санаачилгыг өрнүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэх ёстой.

Халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багт ажиллахдаа дараах баримт бичгийг хөтлөх болон хөтлөхөд өөрийн хувь нэмрээ оруулна. Эдгээр нь:

- Нөхцөл байдлын үнэлгээний маягт;
- Үйл явцын тэмдэглэл;
- Уулзалтын тэмдэглэл;
- Үйлчлүүлэгчтэй холбоотой бусад баримт бичгүүд

Дээрх баримтууд нь үйлчлүүлэгч өөрчлөлтийг хэмжих, нийгмийн ажилтан өөрийн ажлаа үнэлүүлэх, шүүхийн өмнө өөрийгөө өмгөөлөх, нотлоход ач холбогдолтой байдаг.

Халамжийн нийгмийн ажилтан өөрчлөлтийг хэрэгжүүлэхийн тулд дараах ур чадваруудыг эзэмшсэн байвал зохино. Үүнд:

- Аливаа зүйлд хандахдаа хувь хүний зүгээс бус мэргэжлийн зүгээс хандах чадвартай байх;
- Аливаа шийдвэр гаргахдаа үйлчлүүлэгчийн эсвэл бусад мэргэжилтнүүдийн санал бодол дээр тулгуурлах;
- Асуудлыг шийдвэрлэхдээ үйлчлүүлэгчийн нөөц боломж, давуу талд тулгуурлах;
- Асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх, шинийг санаачлах чадвартай байх;
- Шүүмжлэхээс илүү өөрчлөлт шинэчлэлт, сайжруулалтыг эрэлхийлэх;
- Идэвхтэй сонсох, үйлчлүүлэгчийг хүндэтгэх харилцааг эрхэмлэх

28.9. Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

- 28.9.1. нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйлчилгээнийх нь чанарт хяналт тавих, үнэлгээ хийх;
- 28.9.2. шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;
- 28.9.3. халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бусад баримттай холбогдсон тайлбар, лавлагаа гаргуулж авах;
- 28.9.4. мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;
- 28.9.5. нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах;
- 28.9.6. ажлын онцлогоос шалтгаалан тусгай өрөө, эсхүл тусгаарлалт бүхий ажлын байр болон шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангагдах.

Нийгмийн халамжийн тухай хуулиас

Халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багийн гишүүдтэй хамтран үйлчлүүлэгчтэй ажиллахдаа хамтарсан багийн үйл ажиллагааны зарчим болон гишүүдийн ёсзүйн зарчмыг баримтлан ажиллана.

Хамтарсан багийн үйл ажиллагааны зарчим

1. Хамтарсан багийн гишүүд нь тэгш оролцоотой байх
2. Ажил, үйлчилгээ нь шуурхай, цогц, хүртээмжтэй байх
3. Хүүхдийн эрхэд суурилсан, гэр бүлд түшиглэсэн арга зүйг хэрэглэх
4. Хүнийг нас, хүйс, арьс өнгө, үндэс угсаа, шашин шүтлэг, үзэл бодлоор ялгаварлан гадуурхахгүй байх
5. Хүний нэр төр, алдар хүндийг дээдлэн хүндлэх, нууцыг хадгалах
6. Гэр бүл, хүүхдийн байдал, өвөрмөц хэрэгцээ, онцлогийг харгалзах
7. Санхүүгийн хувьд нээлттэй, ил тод байх

Хамтарсан багийн гишүүдийн мөрдөх ёс зүйн зарчим

1. Үйлчлүүлэгчээ хүндлэх, хувь хүнийх нь хувьд эрхийг нь хүлээн зөвшөөрөх
2. Үйлчлүүлэгчтэй зөв боловсон харилцах, давуу тал дээр нь тулгуурлан ажиллах
3. Харилцан итгэлцэл, хүндлэлд тулгуурласан хамтын ажиллагаа түншлэлийн үзэл санаагаар үйлчлүүлэгчтэй харилцах
4. Хүүхдийн оролцоог хангах, тэдний үзэл бодлыг хүндэтгэх
5. Үйлчлүүлэгчийг амьдарч байгаа орчинд нь ойлгох



Халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багт гүйцэтгэх үүрэг

Халамжийн нийгмийн ажилтан өөрийн гүйцэтгэж буй үүрэг, баримталж буй зарчим, ур чадвараараа бусад мэргэжилтнүүдээ манлайлан, хамтарсан багийг тогтвортой, чанартай, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулах ёстой юм. Халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багт өөрийн гүйцэтгэх үүргийг тодорхой болгох шаардлагатай. Үүний тулд 3 алхам хийх хэрэгтэй. Үүнд:

1. *Хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцох. Ялангуяа халамж, үйлчилгээ шаардлагатай үйлчлүүлэгчтэй ажиллах, мэдээллийг хүлээн авахад оролцох*
2. *Хамтарсан багт халамжийн нийгмийн ажилтны оролцоог тодорхой болгох*
3. *Хамтарсан багийн үндсэн гишүүний үүргийг гүйцэтгэх*


Халамжийн нийгмийн ажилтан хамтарсан багийн үйл ажиллагаанд оролцохдоо дараах үүргийг гүйцэтгэх ёстой. Хамтарсан багт халамжийн хуулиар халамж, дэмжлэг тусламж, үйлчилгээ авах шаардлагатай үйлчлүүлэгч ирсэн тохиолдолд хуулийн дагуу хамтарсан багийн үйлчилгээг үзүүлэхэд дэмжлэг үзүүлэн оролцох хэрэгтэй болно.

Үйлчлүүлэгчийг халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамруулах алхмууд:



- 1. Учир шалтгааныг тодруулах:** Үйлчлүүлэгчийн халамжийн тэтгэвэр тэтгэмжид хамрагдах болсон шалтгаан, шалгуур үзүүлэлтүүдэд анхаарлаа хандуулна. Шалтгаан, шалгуур үзүүлэлтэд хүүхэд, гэр бүлийн эсрэг үйлдэгдэж буй хүчирхийлэл байвал нийгмийн ажилтанд мэдээлнэ.
- 2. Мэдээлэл өгөх:** Үйлчлүүлэгчийн халамжийн тэтгэвэрт хамрагдах үндэслэл, холбогдох бичиг баримтын бүрдэл бий болгох талаар мэдээлэл өгнө.
- 3. Чиглүүлэх буюу холбон зуучлах:** Үйлчлүүлэгч холбогдох үйлчилгээг авахын тулд ямар албан тушаалтанд хандах, хэрхэн холбоо тогтоох, ямар бичиг баримт бүрдүүлсэн байх талаар зөвлөн, холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй холбоо тогтооход туслах үүрэг хүлээнэ.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх алхмууд:



1. **Олон нийтийг хамарсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах:** Энэ нь мэдээллийг үнэн зөв хүргэх, тэднийг сэдэлжүүлэх, идэвхижүүлэх, цаг хугацаа болон хөрөнгө, мөнгийг хэмнэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.
2. **Мэдээлэл хүлээн авах, бүртгэх, зөвлөгөө өгөх:** Олон нийтийг хамарсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцож мэдээлэл авсан хүмүүс хамтарсан багийн гишүүдэд хандах явдал нэмэгддэг. Иймээс мэдээллийг бусад гишүүддээ дамжуулах, эдгээр хүмүүст зөвлөгөө өгөх, кейс нээж, үйлчилгээг хүргэдэг.
3. **Нөхцөл байдлын үнэлгээ хийх:** Нөхцөл байдлын үнэлгээг үйлчилгээ үзүүлэх бүртгэл хийх хэрэгтэй.
4. **Амьжиргааг дэмжих зөвлөлд материал хэлэлцүүлэх:** Хамтарсан багийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, халамжийн үйлчилгээнд хамрагдах иргэн, өрхийн талаар мэдээлэл цуглуулж, нөхцөл байдлыг судлах, бичиг баримт бүрдүүлэхэд туслах хэрэгтэй.
5. **Үйлчилгээг үзүүлэх:** Үйлчлүүлэгчтэй харилцан тохиролцож байгуулсан гэрээний дагуу үйлчилгээг үзүүлэх хэрэгтэй.



Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх алхмууд:




1. **Мэдээлэл хүлээн авах, бүртгэх:** Хамтарсан багийн гишүүд мэдээлэл дээр үндэслэн үйлчлүүлэгчийн хаягийг бүртгэж авсаны дараа тухайн иргэн, өрхөд очиж уулзан нөхцөл байдлын үнэлгээ хийнэ. Нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан үйлчилгээ хүргэх буюу хэрэв үйлчилгээ шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд зөвлөгөө өгөн, кейсийг хаана.
2. **Нөхцөл байдлын үнэлгээ хийх:** Нөхцөл байдлын үнэлгээ нь тухайн иргэн, өрхийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээнд хамруулах уу, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах уу, гэрийн халамж, асаргааны үйлчилгээнд хамруулах уу гэдгийг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой. Хэрвээ төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах шаардлагатай гэж үзвэл холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай болдог.
3. **Холбогдох бичиг баримтыг бүрдүүлэх:** Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахын тулд холбогдох бичиг баримтыг бүрдүүлж, тухайн дүүрэг, нийслэлийн засаг даргын захирамжаар төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэрийг гаргуулна. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гарсан тохиолдолд үйлчлүүлэгчийг асрамжийн газарт хүргэж өгнө.

Боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх алхмууд:



Хамтарсан багийн үйл ажиллагааг халамжийн салбараас дэмжих нэг хэлбэр нь нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх явдал юм. Иймээс нөхцөл байдлын үнэлгээг сайн хийж, үйлчилгээ авч буй иргэн, гэр бүлийн гишүүдийг дэмжих боловсрол болон эрүүл мэндийн үйлчилгээг цогцоор төлөвлөх, хэрэгжүүлэх ажил халамжийн нийгмийн ажилтны үүрэг болно.

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ үзүүлэх алхмууд:



НОМ ЗҮЙ

- М. Нямдорж, Т.Амаржаргал, Х.Өлзийтунгалаг, А.Энхцэцэг. (2014). Нийгмийн ажлын макро практик. Алмазпресс. УБ
- М. Нямдорж, Т.Амаржаргал, Х.Өлзийтунгалаг, А.Энхцэцэг. (2013). Нийгмийн ажил халамжийн ажилтнуудад зориулсан гарын авлага, Анулан ХХК. УБ
- НДЕГ (2014) Нийгмийн даатгалын холбогдолтой эрх зүйн актын эмхэтгэл. УБ
- НХҮЕГ (2015) Нийгмийн халамжтай холбогдолтой хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ
- С.Туяа (2016). Насжилт-ахмад настны нийгмийн хамгаалал. УБ
- ХАХНХЯ (2011) Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо. УБ. он
- ХАХНХЯ (2013) Нийгмийн халамжийн шинэчлэл. УБ. он
- УИХ (1992). Монгол Улсын Үндсэн хууль. УБ
- УИХ (2015) Монгол Улсын Нийгмийн даатгалын багц хууль
- УИХ (2012) Монгол Улсын Нийгмийн халамжийн багц хууль
- УИХ (1994) Нийгмийн даатгалын тухай хууль



Хүүхэд хамгааллын тогтолцооны загварыг (хүүхэд хамгааллын хамтарсан багийг) анхан шатны нэгжид (нийслэл, дүүрэг хороонд, орон нутаг сум, багт) бэхжүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 23, 27-р хороо, Сонгинохайрхан дүүргийн 2,10-р хороо, Чингэлтэй дүүргийн 9,10-р хороо болон Архангай аймгийн Хайрхан, Батцэнгэл сум, Эрдэнэбулган сумын 4-р багийг сонгон хэрэгжүүлж байна. Тус төсөл нь 2015- 2018 оны хооронд ЖАЙКА-гийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжих юм.

Төслийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

Үйл ажиллагаа 1: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн чадавхийг бэхжүүлэх

Үйл ажиллагаа 2: Хүүхэд хамгааллын хамтарсан багийн гишүүдийн болон салбар дундын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах

Үйл ажиллагаа 3: Олон нийтийн дунд хүүхэд хамгааллын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа 4: Төслийн хүрээнд хийгдсэн үйл ажиллагааны сургамж, хүрсэн амжилт, үр дүнд үндэслэн холбогдох яамдад нөлөөлөх

Төслөөс хүлээж буй үр дүн:

- Хамтарсан багийн гишүүд нь мэргэжлийн ур чадвар болон хүүхэд хамгааллын үйлчилгээний арга зүйн мэдлэгээ сайжруулж, зорилтот орон нутаг дахь хүүхдүүдэд хамтарсан багаар хамгааллын үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон байна.
- Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд байгууллага хоорондын уялдаа холбоо зохицуулалтыг хангах механизм бий болж, бэхжиж хүүхдийн эсрэг хүчирхийллийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэхээс гадна зорилтот орон нутагт хүүхдийн эсрэг хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээг цаг алдалгүй хүргэх боломж нэмэгдэнэ.
- Хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй хүүхдүүд ба тэдний эцэг эх, асран хамгаалагчдын хоорондын харилцааг сайжруулахад дэмжих, хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлнэ.
- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх төрийн байгууллагуудын зүгээс хүүхэд хамгааллын үйлчилгээнд ач холбогдол өгч ажиллах нь нэмэгдсэн байна.